



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/37

Улаанбаатар хот

Тангараг өргүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны өдрийг тохиолдуулан тусгай шалгалт өгч тэнцсэн, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн Ядамсүрэнгийн Эрдэнэбаатарыг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсүгэй.

2. Тангараг өргүүлэх ёслолын арга хэмжээг “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т даалгасугай.



132003217

БОЛОВСРОЛЫН САЙД, САНГИЙН САЙД, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 06 дугаар сарын 23 өдөр

Дугаар 144/120/436

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зориулалттай барилга  
түрээслэх жишиг үнийн дээд хязгаар тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 1.4 дэх заалт, 2024 оны 169 дүгээр тогтоолын 1.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн боловсрол сургалтын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга түрээслэхэд баримтлах 1 метр квадрат талбайн түрээсийн жишиг үнийн дээд хязгаарыг Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт 57,000 төгрөг, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Налайх, Багахангай, Багануур дүүрэг, аймагт 50,000 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Ачаалал өндөртэй, хотхон хорооллын дундах, газар чөлөөлөх боломжгүй байршилд баригдсан, суурилагдсан хүчин чадалдаа тохирсон иж бүрэн сургалтын тоног төхөөрөмж, хими, физик, дуу хөгжим, дизайн технологийн кабинет, спорт заал, урлаг заал, гадна талбай, орчны тохижилт бүхий хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийн зориулалт бүхий барилга байгууламжийн 1 метр квадрат талбайн түрээсийн жишиг үнийн дээд хязгаарыг 120,000 төгрөгөөр тогтоосугай.

3. Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын гүйцэтгэсэн нийслэлийн дүүрэг, хороодын түрээсийн зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн түрээсийн жишиг үнийн дээд хязгаарт багтаан түрээслүүлэгч талтай холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, ажиллахыг төсвийн шууд захирагч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Боловсролын ерөнхий газарт тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛЫН САЙД

САНГИЙН САЙД

ТӨРИЙН ӨМЧИЙН  
БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

П.НАРАНБАЯР

Б.ЖАВХЛАН

Б.ЦЭНГЭЛ

ATA12937 9116621 9024070582